



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2021 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 355

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох
тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх заалт, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 4 дэх заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 18 дугаар захирамж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.10, 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Нийслэлийн төсвийн хөрөнгөөр бий болсон нийт 148,919,300.00 (нэг зуун дөчин найман сая есөн зуун арван есөн мянга гурван зуун) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Цагдаагийн ерөнхий газрын харьяа Экологийн цагдаагийн албаны үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Цагдаагийн ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа Ж.Болд нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132007773

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 12 дүгээр сарын 28-ны өдрийн
33 дугаар тогтоолын хавсралт

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА ЭКОЛОГИЙН ЦАГДААГИЙН
АЛБАНЫ БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр, марк, техникийн үзүүлэлт	Тоо шир хэг	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)
1	Автомашин, Хьюндай элентра О, 09-21 УНУ (арал-kmhdt41babu247724)	1	94,400,000.00	94,400,000.00
2	Иж бүрэн компьютер	30	1,584,110.00	47,523,300.00
3	Хэвлэгч (өнгөт-7, хар-10)	17	411,529.42	6,996,000.00
	Нийт дүн			148,919,300.00 (нэг зуун дөчин найман сая есөн зуун арван есөн мянга гурван зуун)